



**ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот


Баримтлах чиглэл батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, тус газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийн тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

Хоёр. “Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийн тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэл”-ийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Радио, телевиз, нийгмийн мэдээллийн сүлжээний бодлого, зохицуулалтын хэлтэс (Р.Эрдэнэбилэг)-т даалгасугай.


ДАРГА



Б.ЧИНБАТ

0002217

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн
газрын даргын 2017 оны 07 сарын 03
өдрийн 8/71 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙГ ТООН ТЕХНОЛОГИД ШИЛЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэлийг тодорхойлно.

ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Тоон радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэхдээ дараах байдлаар бүс нутгийн хуваарилалт хийнэ. Үүнд:
- 2.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан тоон радио өргөн нэвтрүүлгийн газрын дамжуулах сүлжээ;
- 2.1.2. Хот, сум, суурин газрыг хамарсан тоон радио өргөн нэвтрүүлгийн газрын дамжуулах сүлжээ;

ГУРАВ. НЭВТРҮҮЛЭХ ТЕХНОЛОГИ

- 3.1. Тоон радио өргөн нэвтрүүлгийн системийг Монгол Улсад нэвтрүүлэхдээ Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ОУЦХБ)-аас батлан гаргасан дараах технологиудыг ашиглана. Үүнд:
- 3.1.1. Улс орныг бүрэн хамарсан тоон радио өргөн нэвтрүүлгийн сүлжээ байгуулахад DRM30 технологийг ашиглана.
- 3.1.2. Хот, сум, суурин газрыг хамарсан тоон радио өргөн нэвтрүүлгийн сүлжээ байгуулахад DAB+ технологийг ашиглана.

ДӨРӨВ. АШИГЛАХ ДАВТАМЖИЙН ЗУРВАС

- 4.1. Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид ОУЦХБ-ын GE06 гэрээгээр баталгаажсан давтамж болон BS.1615 зөвлөмжийг тус тус баримтална. Үүнд:

Технологийн нэр	Долгионы төрөл	Ажиллах зурвас	Зөөгчийн төвийн давтамж	Давтамжийн зурвас /өргөн/
DRM30	Урт долгион	148.5-255кГц	164кГц 209 кГц 227 кГц	9-20 кГц

	Дунд долгион	526.5-1606.5 кГц	882 кГц, 990 кГц	9-20 кГц
	Богино долгион	3-26МГц	72/60кГц 48/30кГц 48/95кГц	9-20 кГц
DAB+	Давтамжийн III зурвас	174.0-230 МГц	Зохицуулалтын баримт бичгийн дагуу	1.5МГц

ТАВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 5.1 Радио өргөн нэвтрүүлгийг ард иргэдэд тэгш, шударга зарчмын үндсэн дээр орон зай, байршлаас үл хамааран хүлээн авах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.
- 5.2 Улсын төсөв, гадаадын зээл тусламж, бүх нийтийн үүргийн сан болон бусад хөрөнгө оруулалтаар шинээр аналог радио өргөн нэвтрүүлгийн системд өргөтгөл, шинэчлэл хийхгүй.
- 5.3 Тоон технологийн нэвтрүүлэгчээр тэргүүн ээлжинд төрөөс зайлшгүй дамжуулах радио сувгуудыг дамжуулна.
- 5.4 Аналог радио хүлээн авагчийн импортод хяналт тавьж, хязгаарлах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 5.5 Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан тоон радио өргөн нэвтрүүлгийн газрын дамжуулах сүлжээ нь төрийн өмч байна.
- 5.6 Хот, сум, суурин газрыг хамарсан тоон радио өргөн нэвтрүүлгийн сүлжээг нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийж болно.
- 5.7 Радио өргөн нэвтрүүлгийн контент бэлтгэгчийн студи болон хэрэглэгчийн хүлээн авах тоног төхөөрөмжийг солих асуудлыг зах зээлийн зарчмаар шийдвэрлэнэ.

ЗУРГАА. ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ТӨЛӨВЛӨЛТ

- 6.1 Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх арга хэмжээг тодорхой үе шаттайгаар нэгдсэн төлөвлөлтийн дагуу удирдан зохион байгуулж хэрэгжүүлнэ.
- 6.2 Үндэсний болон хувийн тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг хугацааны хувьд ялгаваргүй зэрэг байгуулж болно.
- 6.3 Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг зохион байгуулахдаа онцгой байдал, гамшгийн үеийн мэдээг зарлан мэдээлэх боломжийг бүрдүүлнэ.
- 6.4 Тоон технологид шилжих шилжилтийн үйл явц хангалттай түвшин (Монгол Улсын нийт өрхийн 80-с дээш хувь нь тоон радио өргөн нэвтрүүлгийг хүлээн авах боломж бүрдсэн)-д хүртэл аналог болон тоон радио өргөн нэвтрүүлгийн системийг зэрэгцүүлэн /бүс нутгаар зэрэгцүүлэх/ ажиллуулна.
- 6.5 Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зах зээлийн эрэлт хэрэгцээг чанартай, хямд хэрэглэгчдийн хүлээн авах төхөөрөмжөөр хангах зорилгоор тоног төхөөрөмжийн татварын хөнгөлөлтийг бий болгох талаар холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

- 6.6 Харилцаа холбооны зохицуулах хороо нь аналог радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг хийж, тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээний тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг шинээр боловсруулж, олгох ажлыг зохион байгуулна.
- 6.7 Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ нь дамжуулах станц суурилуулахад шаардлагатай цахилгаан хангамж, цамхаг, байр талбай, ажиллах хүчний бэлэн байдлыг хангуулах, шилжилтийн үед бүх шатны инженер, техникийн ажилчдыг өргөн хүрээтэйгээр сургалтад хамруулах ажлыг шуурхай зохион байгуулна.
- 6.8 Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ нь дамжуулах станцуудад радио программыг хүргэх дэд бүтцийг шинэчлэн сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 6.9 Тоон радио өргөн нэвтрүүлгийг олон нийтэд сурталчлах ажлыг төр болон хувийн хэвшил хамтран зохион байгуулна.
- 6.10 Аналог радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээний нэвтрүүлэгчийг 2021 оны 10 сарын 15 өдөр унтраана. Тоон системд шилжих шилжилтийн нөхцөл байдлаас шалтгаалан уг хугацаа өөрчлөгдөж болно.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Энэхүү бодлогын баримт бичгийн 4.1-т дурдсан байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийг үндэслэн давтамжийн төлөвлөлт болон техник, технологи, тоон системийн шилжилттэй холбоотой тус бодлогын баримт бичигт тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж болно.